

**Урансайхны эхийн зохиомж, бүтцийн  
нэгэн өвөрмөц онцлогийн тухай**

**Б.Пүрэв-Очир (УБИС)**

Урансайхны (уранзохиолын) эх, түүний бүтэц, зохиомж, хэл найруулгад албан хэргийн, эрдэм шинжилгээний, сонин нийтлэлийн г.м. найруулгын бусад төрлөөсөө ялгарах олон өвөрмөц онцлог байдаг. Түүний нэг нь туурвилзүй хийгээд уранзохиол задлалын талаасаа зохиолын **байгууламж, зохиомж** хэмээх ойлголтод хамаардаг эхзохиогчийн тусгай тайлбар, тэмдэглэл маягтай **эхлэл** (лат. expositio), **эхлэл үг** (гр. prologos) гэдэг зохиомжийн хоёр өөр бүрдэл хэсэг юм.

Эхийн бүтэц, байгууламж, зохиомж, хөтөлбөржилтөд чухал учир холбогдолтой, зохиолын **"үйл явдал"** болон өгүүлэгдэхүүнийг (сюжет) залган хөгжүүлэхэд утгын холбоос маягтайгаар байрлан ордог энэхүү **"эхлэл"** ба зохиомжийн тусгай хэсэг болох **"эхлэл үг"**-ийг эхзадлал хийгээд уранзохиол задлалын талаас нь төдий л тусгайлан судалсангүй иржээ.

Гол төлөв урансайхны эхийн зохиомж, найруулгад л хамаатай байдаг энэхүү **эхлэл үг** ба **эхлэл** нь эхзохиогчийн тодорхой зорилгоос үүдэлтэй, хэд хэдэн хэв маягтай, утга ба хэлбэрийн холбоос болох талаасаа ялгамжтай, өвөрмөц үүрэг бүхий бүрдэл хэсэг юм. Тухайлбал, урансайхны эхийн **эхлэл** ба **эхлэл үг** нь эхзохиогчийн **тайлбар, уран сэтгэмж, байгалийн зураг дүрслэл, үйл явдлын өгүүлэмжийн гол шугам өрнөх угтвар нөхцөлийг бүрдүүлсэн нийгэм-ахуйн зураглал, зохиогчийн хүүрнэл бодрол, оруулбар (insertion), хэлбэржсэн агуулгыг илэрхийлэх зорилготой дүрслэл, "би" баатрын бясалгал, хөрөг дүрслэл** г.м. олон хэв маягтай **"бүрдүүлбэр"** элемент байдгийг утгазохиолын хэлний баримт харуулж байна.

Юуны өмнө, үүнийг уранзохиол (урансайхны эх)-ын хоёр баримтаар яльгүй тодосгон харъя. Үүнд: А.Толстойн **"Мөнгөн ноён"** (Князь серебряный)-нд олон жил харь газар дайн байлдаанд явсан Мөнгөн ноён эх нутгийнхаа барааг хараад догдлон байгаа сэтгэлийг Орос нутгийн үзэсгэлэнт байгалийн сайхантай холбон **эхзохиогч** буюу **зохиолчийн** хүүрнэлээр зохиолын өгүүлэгдэхүүнтэй холбон үзүүлсэн

байгалийн дэвсгэр хийгээд баатрын сэтгэлийн байдлын эхлэл нь нэгд, А.Толстойнхоор:

*Весело было теперь князю и легко на сердце возвращаться на родину. День был светлый, солнечный, один из тех дней, когда вся природа дышит чем-то праздничным, цветы кажутся ярче, небо голубее, вдали прозрачными струями зыблется воздух, и человеку так будто бы душа его сама перешла в природу, и трепещет на каждом листе, и качается на каждой былинке...* гэсэн байдалтай байгаа бол, үүнийг жишин харьцуулах зорилгоор акад. Б.Ринчений орчуулсан монгол эхээр нь харвал:

*Ноён нутагтаа буцаж яваа нь сэтгэл тэнүүн, дотор уудам. Тэнгэрийн өдөр маш цэлмэг сайхан, нарны гэрэл гиймэл тул түмэн бодис нэн сэргэлэн сайхан үзэгдэж, цэцгийн өнгө улам хурц, тэнгэрийн өнгө улам хөх, алс хол зэргэлзэн мяралзаж, дотор онгойж, тэнүүн сайхан болоод, навч бүрийн нахилзах, өвс бүрийн найгалзахад, өөрийн бие чингэж нахилзан найгаж байгаа мэт таатай санагдах сайхан өдрийн нэгэн нь болжээ...* гэсэн эхлэл болсон нь сонин байна. Тэгвэл Д.Нацагдоржийн “Шувуун саарал” (бяцхан үлгэр, 1934) бол маш нарийн зохиомж, хийцтэй урансайхны эх юм. Энэ нь Д.Нацагдоржийн “Бүрэн түүвэр” (1996)-т орсноор XVI хэсэгтэй, утгын холбоо нь үлэмж нарийн болох нь хүүрнэл эхийн хэл найруулгаасаа тодорхой харагддаг.

*“Эх”-ийн цогцолборуудыг ажиглавал, 1-р цогцолбор нь зохиогчийн хүүрнэл дэвсгэр өгүүлэмж эхлэл байгаа нь сонин байдаг. Үүнд: Хөндий талын зэрэглээ мяралзан жирвэгнэх нь холоос үзэхэд сонин. Хэдэн жижигхэн юм түүний дотор сүүмэлзэх нь холоос үзэх нүднээ яахин даруй танигдана. Уудам газар дураар сэлгүүцэх хээр хөдөөгийн цэнгэл. Хурдан морины яралзан ирэх нь эр хүний бахдал. Ойртон үзвэл, хэдэн залуус морь тарлаж байна. [...]* гэж урансайхны эх эхэлж, цааш улам нарийн хөтөлбөржин зохиомжлогдсон байдаг.

Бас, С.Удвалын “Одгэрэл” туужийн уншигчийн анхаарлыг татах зорилго бүхий эхлэл үг, Д.Цэвэгмидийн “Булшин дээр” найраглалд “аялан явагч, газарч өвгөн” хоёрын тухай өгүүлэгчийн тайлбар маягийн тусгай хэсэг, Д.Содномдоржийн “Навсайдамба ба түүний нөхөд” зохиолд уг зохиолыг бичих болсон шалтгааныг өгүүлсэн хэсэг, мөн Ш.Гаадамбын “Элбэг дээл” хүүрнэл эхийн эхний хэсэг, Л.Түдэвийн “Нууц биш нууц” өгүүллэгийн эхлэл үг зэрэг нь эхлэл үгийн сонин жишээ болох билээ. Нэг жишээг нь татаж харъя. Үүнд зохиолч Ш.Гаадамбын “Элбэг дээл”-ийн эхлэл үг ийнхүү эхэлж байна: “Эрхэм уншигчдын дотроос хэрэв сурвалжлан бичихийн зовлонг үзсэн хүн байвал, ажилд гарамгай боловч даруу бүрэг хүнтэй харилцаад нийтлүүлэх олзгүй буцахаас гомдолтой юм орчлонд ховорхныг мэднэ байх аа. Сайн малчдын дөрөвдүгээр зөвлөгөөний үеэр 12-р сарын нэг хүйтэн, тунгалаг өдөр би, зочид буудалд очиж, нэг малчин хүүхэнтэй ярилцаад яг тэгж хоосон буцах шахаж билээ.” [...]

гэж эхлээд улмаар өгүүллэгийн сюжетийн өрнөлттэй холбон залгаж байгаа нь сонин зохиомж юм.

Урансайхны эхийн найруулгын энэ онцлог нь *нэг талаас*, уранзохиол судлалын, *нөгөө талаас*, эхийн хэлшинжлэл, эхзадлал, эхийн зохиомж найруулгын учир холбогдолтой асуудал гэж үзэж болно. Доктор Д.Галбаатар “Уранзохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь” гэдэг бүтээлдээ *эхлэл* (лат. expositio), *эхлэл үг* (гр. prologos) хэмээх хоёр ойлголтын талаар: “*Эхлэл*” нь латин хэлний тайлбарлах, тайлбар хэмээх утгатай үгээс гаралтай нэртомъёо болно. Зохиолын өгүүлэгдэхүүний дарааллын бүрдэл хэсэг болно. Зохиолын нийт өгүүлэгдэхүүн, зөрчил, тэмцэл өрнөх бололцоог нээж байгаа хэсгийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, зохиолын зөрчлийн учир шалтгаан, баатруудын хооронд үүсэх харилцааны хэв маяг, нийгмийн зөрчил дүр дүрслэлийн талаар дэлгэрэнгүй биш боловч урьдчилсан ямар нэг дүрслэлээр дамжуулан танилцуулах зорилготой зохиолын өгүүлэгдэхүүний хэсгийг *эхлэл* гэдэг. Зохиол тусгай *эхлэл* (бүрдэл) хэсэгтэй байхаас гадна ердийн байгалийн зураглал, хүний хөрөг дүр, харилцаа яриа, өгүүлэгчийн хүүрнэл, дотоод яриа г.м. зохиомжийн аль нэг зүйл байх нь ч бий. Тухайн зохиолын зохиомжийн онцлогоос шалтгаалан, зохиолын эхэнд, дунд, адагт хаана нь ч байрласан байж болно. Тухайлбал, Л.Түдэвийн “Оройгүй сүм” романы эхэнд нэгэн сохор хүн тэмтчин яваагаар *эхэлдээ* боловч энэ нь зохиолын өрнөлөөс харвал зохиолын *төгсгөл болох* нь тодорхой болж, харин төгсгөлд уг зохиолын баатар Санжийн хувь заяаны *эхлэл цэг* өгүүлэгдэж байгаа нь уг зохиолын *эхлэл* нь романы адагт байрлалтайг харуулна. Д.Нацагдорж “Үзэгдээгүй юм” өгүүллэгийнхээ агуулгад шууд хамааралтай байгалийн зураглалыг хийсэн нь *эхлэлийн* өөр нэг хувилбар болно... (3:434) гэж тэмдэглэсэн бол “*эхлэл үг*”-ийн тухайд: “*Эхлэл үг*” гэдэг нь грек хэлний өмнө, урд, угтвар гэсэн утга бүхий үгээс гаралтай нэр томъёо болно. Зохиолын өгүүлэгдэхүүний бүрдэлд хамаарахгүй. Харин зохиолын зохиомжтой холбоотой ойлголт юм. *Эхлэл үг* нь зохиолын үйл явдал, дүрийн хөгжилд хамаарахгүй (3:435) гэжээ.

Эндээс харахад *эхлэл үг*, *эхлэл* хоёр нь гол төлөв урансайхны эхийн *зохиомж*, *бүтцийн талд* хамаатай өвөрмөц сонин бүрэлдүүлбэр бөгөөд түүнийг:

А. *Эхлэл үг*, түүний үүрэг, байрлал, утга, хэрэглээний онцлог;

Б. *Эхлэл*, түүний үүрэг, байрлал, утга, хэрэглээний онцлог гэсэн хоёр шугамаар авч үзэж, зарим санаа тайлбар хийж, тусгайлан судалж болох мэт санагдав.

Э.Верлих нарын зэрэг эрдэмтэн эх (текст)-ийг бүтэц, өгүүлэхүйн хэв шинжүүдийн хэв маяг, хэлбэрийн ба хэлзүйн холбоо, түүний хэрэглүүр, эхийн доторх өгүүлбэрүүдийн дараалал, эхийн утга ба мэдээллийн төгс авцалдаат чанар, эдгээрийн гинжин холбоогоор нь: (функциональный стиль гэдэг Б.П.)

1. Дескриптивные или описательные (тоочимж эх)
2. Нарративные или повествовательные (хүүрнэмж эх)
3. Объяснительные (тайлбарламж эх)
4. Аргументативные или рассуждение (эргэцүүлэмж эх)

гэсэн өгүүлэхүйн үйлийн утга-үүргийн хэв шинжүүдэд (10) хуваасан байдаг. Эдгээр хэв шинжүүд нь зохиомжийн талаасаа ч ялгаатай. Бидний сонирхон судалж байгаа нөгөө *эхлэл үг*, *эхлэл* бол тоочимж (описание), хүүрнэмж (повествование), эргэцүүлэмж (рассуждение), хөрөг (портретизация) г.м. тоочимж ба хүүрнэл хэв шинжид илүү хамаатай юм гэж үзэж болмоор байна.

**А. Эхлэл үг**, түүний үүрэг, байрлал, утга, хэрэглээний онцлогийг одоо яльгүй тодруулан авч үзье. **Эхлэл үг** нь аливаа эхийн зохиомж, бүтэц, утга ба хэлбэрийн нэгдмэл, авцагдаат чанарыг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй хэсэг юм. Харин **эхлэл үг** бол зохиолын өгүүлэгдэхүүний бүрдэл хэсэг биш, зохиомжийн бүрдэл хэсэг болдог хүүрнэл ба яруу шүлэг бөгөөд эрдэмтэн Д.Галбаатар “Шүлэг зохиол бичигчид өөрийн бүтээлийн өлзий бэлгэдэл, учир зорилго, ач холбогдлыг ухуулан ойлгуулах, уншигч, сонсогчийн анхаарлыг татах, өөрөөс өмнөх үеийн их зохиолч, яруу дууч, эрдэмтэн мэргэд, багшийн эрдэм чадал, хайр энэрэл, ач тусыг дурдан өгүүлэх, бурхан тэнгэр, эрдэмт багш тэргүүтнээс оюуны бүтээх хүч чадал, соёрхлыг хүсэн гуйх, уншигчдад билэг ерөөл айлтгах зэргээр тусгай шүлэг тэргүүтнийг бичдэг ёс бий” (3:435) гэсэн нь анхаармаар сонин санаа юм. Жишээлбэл, яруу найрагч, Ч. Дагвадорж <<Хотгойд аялгуу>> яруу найргийн номынхоо эхлэл үгийг:

**Янжинлхамын хишигт шүтэн  
Яруу хүрхрэлд автагч тантай  
Яргуйт зуны униарт согтохоор  
Ядуу шүлэгч бийрээ барив.**

гэж уншигч авгай нарт хандаад, улмаар,

**<<...Бүрэлдэж тогтсон эд эс минь хотгойд  
Бүхнээс ялгарах овог минь хотгойд  
Бүрэн улсдаа дуурсах алдар минь хотгойд  
Бүдэг, тод мөр минь түүхэндээ хотгойд...>>**

гэсэн <<өөрийн тэмдэглэлээс авсан>> эхлэл үгээр уянгын шүлгийн ном <<Хотгойд аялгуу>>-ныхаа гол утга санааг өргөж, өргөл үг болгосон байгаа сонин баримтыг хэлж болох билээ.

Ардын уранзохиолч Цэндийн Дамдинсүрэн гуай “**Буурал ижий минь**” шүлэг буюу урансайхны эхдээ:

**Халх Монголын малчин  
Хатгин овгийн нүүдэлчин  
Харц язгуурт Дамдинсүрэн  
Харь газар суухдаа**

**Эх нутгаа эрмэлзэж  
Элгэн саднаа дурдаж  
Эцэг эхээ санагалзаж**

**Эгшиглэн шүлэглэсэн нь энэ байна.**

гэсэн “**өөрийн бүтээлийн учир зорилго**”-ыг өгүүлсэн **эхлэл үгээр** эхэлсэн байгаа жишээг бас дурдаж болох юм.

Тэгвэл зохиолч Ц.Уламбаяр гуай “**Хүүшийн учир**” өгүүллэгээ “**Би энэ харамсалтай домгийг Тамир сумын “Гэрэлт зам” нэгдлийн зуслангийн айлуудаар явж байхдаа сонссон юм...**” гэсэн **тайлбарламж-эхлэл үгээр**, С.Удвал гуай “**Одгэрэл**” туужийнхаа эхэнд “**Миний сайн таних нэг эмэгтэй над удаан хугацаанд олон дахин ярьсан ярианаас нь үндэслэж, үүнийг бичлээ. Харин тэхдээ ярьсан яриаг нь хэтрүүлсэн зүйл ер байхгүй. ихээхэн хасаж, зарим зүйлийг нь зөөлрүүлсэн, хүмүүсийн нэрийг хэвээр нь бичээгүй болохыг эхэнд нь хэлье. Эрхэм уншигчид уншиж үзээд, хүмүүсийн одоогийн амьдралыг өөр хэлбэрээр өргөн дэлгэр бичих нь зүйтэй юм гэж үзвэл түүнээ харамгүй хэлэхийг хүснэ**” гэж “**Одгэрэл**”-ийнхээ **сэдвийг хэрхэн олсон хийгээд уншигчдад**

**хандсан эхлэл үгээр**, зохиолч Бөхийн Бааст гуай “**Алтайн хөх дөнөн**” (хүүрнэл эхийг) өгүүллэгээ: “*Цасан цагаан онгоц маань мөнх цаст, домогт Цамбагаравын зүүн сугад хэдэнтээ дайвалзав. Төрсөн өссөн нутгийн минь сэтгэлд дулаан, зүрхэнд зөөлөн газар нутаг, нүдний өмнө жирэлзэн өнгөрч эхлэв.*

Цагаан түнгэ (үнэндээ цагаан дэрс гэсэн үг) гэдэг газар нэгэн сум ард олон хэдэн мянган малтайгаа өлхөн намаржиж, өвөлжиж, хаварждагаар барахгүй, хавар нь зөндөө газар тариа тарьдаг, намар нь хаа л бол хаа хадлан авдаг хишигт нутаг минь шаргалтан харагдахлаар бие сэтгэл нэг л хачин боллоо. Цагаан түнгэ нутаг бол Ховд голын нэгэн уужим цүлхгэр тохой юм л даа...” гэсэн **эх зохиогчийн хүүрнэл бодрол үгээр эхэлсэн** байгаа зэргээс ажиглавал “**эхлэл үг**” нь аливаа эхийн зохиомжийн талд хамааралтай тусгай бүрдэл бөгөөд үүргээрээ хэд хэдэн янз байдаг нь тодорхой аж.

Урансайхны эхүүдийг задлан үзэхэд, яруу найргийн төрөл зүйлд ч өвөрмөц **эхлэл үг** байж болох нь баримтаас харагдаж байна. Ялангуяа **эпиграф** маягтай **эхлэл үгийг** яруу найргийн эхийн зохиомжид цөөнгүй хийдэг байна. Жишээлбэл, эрдэмтэн зохиолч Б.Ринчен “**Бэр цэцэг**” шүлэгтээ Густа Фучиковад зориулсан:

**Уудам сайхан манай нутгийн.**

**Уул талаар өнгийн цэцэг олон**

**Онц л түүний дундаас бэр цэцэг**

**Олны дундаас сэтгэлд хайртай сайхан**

гэсэн **эхлэл үгийг** шигтгэсэн байхад, яруу найрагч М.Цэдэндорж “**Хайртдаа**” шүлэгтээ Галидасын “**Үүлэн зардас**”-аас татаж:

**Сайхан бүсгүйн хөл хүрэхэд**

**Гаслангийн мод цэцэглэнэ**

гэсэн ишлэлээр эпиграф маягийн **эхлэл үг** болгосон байдаг. Бас **эхлэл үг** нь зөвхөн урансайхны найруулгад төдийгүй эрдэм шинжилгээний найруулгад ч зохиомж, бүтцийн чухал хэсэг болж ордгийг баримт харуулж байна. Монголын эрдэмтэн, акад. Б.Ринчен “**Үгийн утга учир**” хэмээх судалгааны өгүүллэгээ: “**Бид цөм монгол үгээр хэлэлцдэг. Тэгэхдээ бид хэлээ мэддэг гэж хэлэлцдэг, боддог шүү дээ. Гэтэл, бид, өөрийнхөө хэлний чухам хэдэн үгийг мэддэг бол? гэж өөртөө асуулт тавьж болно. Энэ асуулт бол дэмий шалиг асуулт биш. Бид, өөрийнхөө хэлийг аль хир мэддэг вэ. Манай мэдлэг сонирхлын хүрээ аль хир өргөн байна. Бидний уншсан, мэдсэний дэлгэр, хомс нь аль хир байна гэдгийг магадалж мэдэхэд хэрэгтэй сонин асуулт гэж үзэлтэй...**” гэж уншигч сонсогч авхай нарыг өдөж сэрээсэн, асуудал дэвшүүлсэн **эхлэл үгээр** эхэлж, эрдэм шинжилгээний эхийг зохиомжилсон байхад, доктор Д.Бадамдорж “Монгол хэлний утга судлалын үндэс” гэсэн эрдэм шинжилгээнийхээ бүтээлийн **эхэнд** акад. Ш.Лувсанванданы “**Утга гэдэг нь харьцаа юм, харьцаа гэдэг нь утга юм.**” гэсэн онч мэргэн үг, дүгнэлтийг сэдэл үгийн маягтайгаар шигтгэн байрлуулж эхэлсэн байдаг.

Оросын найруулгазүйч эрдэмтэн Д.Э.Розенталь “**Секреты стилистики**” (1999) номынхоо “**Эпитеты**” гэдэг сэдэвт хэсэгт: “**Синий туман. Снеговое раздолье, тонкий лимонный лунный свет.**” (С.Есенин) гэсэн эпиграфыг **эхлэл үг** болгож хийсэн байгаа зэрэг олон баримт дурдаж болох.

Дээр дурдсан мэт баримтуудаас харахад, “эхэл үг”-ийг хэн нэгэн зохиогчийн ямар нэгэн зохиолоос авсан ишлэл, тайлбар үг, онч мэргэн үг, шүлэг, зүйр цэцэн үг, оньсого таазаар, хэвшмэл ба өвөрмөц хэллэг, зохиогчийн хүүрнэл, утга зохилдох үлгэр сэлтээр хийж зохиомжлон байрлуулж болдог гэж үзэх үндэстэй байна. Энэ нь бас уламжлалтай бөгөөд судар бичгийн хэлний <<өргөл үг>>, <<тахил үг>>, <<залбирал үг>>-ийг үүнд хамааруулан үзэж болно. Дээрх зүйлүүдийн тодорхой жишээ бол “Сайн номлолт эрдэнийн сан субашидын тайлбар чандманын түлхүүр хэмээгдэх оршвой” сургаалын зохиол дахь урансайхны хүүрнэл эхүүд-“утга зохилдох үлгэр”-үүдийн **тайлбар шүлэглэл** юм. Жишээ нь: 1 дүгээр бадгийн тайлбар буюу утга зохилдох үлгэрийн “эхлэл үг”- шүлэглэл нь:

**Ухаантан мэргэд хэдий эрдэмтэй боловч**

**Улам улам мэргэжихийн тулд ном судар цуглуулью**

**Урсах мөрөн бүгд уламжлан дамжсаар**

**Усны сан болсон их далайд цутгах адил...**

гэсний утга нь: гээд үлгэрийг эхэлдэг ёстой билээ.

**Б. Эхлэл**, түүний үүрэг, утга санаа, хэрэглээний онцлогийг урансайхны эхийн баримт хэрэглэгдэхүүнд тулгуурлан ажиглавал, **эхлэл нь** аливаа эхийн **байгууламж** хийгээд **зохиомжид** чухал үүрэгтэй, туурвилзүй талаасаа эхзохиогчийн ургуулан бодохуйтай нягт шүтэлцсэн, эхийн өгүүлэгдэхүүний тал буюу өгүүлэмжид нэвчин холбогдох зорилго бүхий утга санаа, мэдээллийн холбох хэрэглүүрийн үүргийг давхар гүйцэтгэдэг эхийн тийм бүрдэл хэсэг юм гэж үзэж болно. Урансайхны эхийн зохиомжид хамаарах **эхлэл нь** байрлал, үүрэг, утга, хэв маягийн хувьд хэд хэдэн янз байгааг зарим эхийн баримтаар яльгүй тодруулах оролдлого хийв. Үүнд:

**а.** Тухайн урансайхны эхийн өгүүлэмжийн дэвсгэр орчин болгох зорилго бүхий **байгалийн зураглал эхлэл**, үүнийг Д.Нацагдорж, Ч.Айтматов, Ч.Лодойдамба, С.Эрдэнэ нарын зэрэг зохиолчийн урансайхны хүүрнэл эхийн баримтаар баталж болно. Үүнд:

Д.Нацагдоржийн “Адуу манаад” өгүүллэгийн (урансайхны эхийн) **байгалийн зураглал эхлэл нь:**

**Үүрийн цагаан гэгээ тусмагц, хөхөө шувуу урьхнаар донгодох дуу уулын цуурай ба салхины аятай хослон, өргөн талд дэлгэрэнгүйеэ хангинаж, яруухнаар дуурсмагц, адуугаа манаж байсан залуу хүү Цогт агшин зуур дугхийсэн нойрноос сэрэн босож таeltaйхнаар эвшээн суниагаад, гарынхаа араар нүдээ арчин, дөрвөн зүгт хандвал энэ үе сайхан зуны тэргүүн сарын шинэд тул, дэлхийн бодис ба цагийн улирал үнэхээр тааламжтай. Хөх тэнгэр тунгалагаар цэлмээд, хөвөн үүл хэсэг хэсгээр тунана. Дэргэдэх цэцэг өвсөнд нимгэн цагаан хяруу гилтэгнээд, тэртээгийн ой модонд ногооны униар залгалдана. Урьхан салхи зөөлнөөр найгаад, ариун агаар цээж дүүрэн амьсгалуулна. Удалгүй дүгрэг том нар мандан гарч ирэхэд урьдаар баруун ба хойд уулсын орой ба энгэрээр гэрэл тусаад, (дараагаар) өмнөх их талд туяа нийтлэн шарлав.** гэж эхэлж байх ба энэ нь цааш өрнөлтэй авцалдсанаар

Үүнд Цогт хүү нэг зэрэг бахдаад, их л баясгалантай байдлаар гялбалзан, уурга тулж мордон, адууныхаа дэргэд хүрвэл [...] гэсэн

байдлаар холбогдож эх бүтэж эхэлж байгаа билээ. Жич тэмдэглэх нь: бид Д.Нацагдоржийн “Адуу манаад” өгүүллэгийг эх, түүний зохиомж, өгүүлбэрийн бүтэц, найруулгын талаас нь бид тусгай судалгааны номдоо нэлээд дэлгэрэнгүй задалсан (4:210-222) болно.

Ч.Лодойдамбын “Манай сургуулийнхан” туужийн (урансайхны эхийн) **орон цагийн харьцаатай хосолмол байгалийн зураглал дэвсгэр нь:**

*Манай оронд олонтоо тохиолддог зуны улирлын эхлэл өдрүүдийн нэг. 1980 оны 6-р сарын 10-ны Бямба гараг. Тэнгэрийн гүнд энд тэнд харагдах бут бут цагаан үүлс дэлгэсэн цэнхэр магнигийн дээр тархагдан хаягдсан хөвөн шиг харагдаж, хөдлөн нүүсээр сэвсийн сарнин замхарч, ор сураггүй алга болоход зөөлөн хилэнгийн өнгөтэй тунгалаг тэнгэр улам ч гуа сайхан болж харагдаж байлаа. [...]* гэж эхлээд цаашид хөтөлбөржин,

Энэ жирийн нэгэн сайхан өдөр надад жир бус явдал тохиолдлоо [...] гэсэн байдлаар **эхийн зохиомжийн зангилаа хэсэгтэй** нөхцөлдөн холбогдож байна.

Чингиз Айтматовын “Далайн хөвөөний алаг хав толгой” урансайхны эхийн **сюжеттэй холбон нөхцөлдүүлсэн байгалийн зураглал эхлэл нь:**

*Нэвтэлшгүй өтгөн манан хөвөлзсөн жихүүн шөнө Агнуурын тэнгисийн бүх эргийн дагуу, тэнгис газар хоёрын бүх фронтын дагуу мөнхийн хоёр догшин хүчин тэмцэлдэж, газар нь тэнгисийн түрэлтийг сөрж, тэнгис нь газар өөд эцэж цуцахыг үл мэдэн давшилсаар байлаа.*

*Харанхуйн дунд тэнгис далай энэлэн хурхирч, эргийн хавцлыг мөргөн буцна. Хатуу чулуун газар тэнгисийн давалгааны балбахыг хариулан хүчлэн уухилна.*

*Тэнгис газар хоёр анх бүтсэн цагаас хойш, өдөр шөнө гэж болдог болсон цагаас хойш үргэлж ингэж тэмцэлдэн ирсэн бөгөөд хойшид ч газар, ус гэж байсан цагт өдөржин шөнөжин ингэж сөрөлдөж байх биз.*

**Өдөржин шөнөжин** [...] гэж эхлээд цааш:

Газар дэлхий дээр бас нэг шөнө өнгөрөв. Энэ бол түүний далайд явахын урд шөнө байв. Энэ шөнө тэр унтсангүй. Амьдралдаа анх унтсангүй, амьдралдаа анх удаа нойргүй хонож үзэв... гэсэн байдлаар өгүүлэгдэхүүн буюу сюжеттэйгээ холбогдож байна.

С.Эрдэнийн “Малын хөлийн тоос” хүүрнэл эхийн, өгүүлэмжтэй холбон нөхцөлдүүлж байгаа байгалийн зураг эхлэл нь ч үүнийг бататгах бас нэг баримт болж чадах билээ. Үүнд:

*Найман сар дундаа орж ногооны үзүүр үл мэдэгхэн модширч, хөх номин тэнгэр газраас улам холдсон мэт уужимхан цэлийж салхи сэлүүхэн үлээх болжээ. Байгал ертөнцийн хишиг бүрдэж малчин ардын гэр хотлоор идээ цагаа дэлгэрсэн энэ сайхан цаг улирлын нэгэн сайхан өглөө билээ.*

*Өмнө уулсын бэл улаан шаргал элсэн манхантай умар уулсын бэл униартах ногоон дэнжтэй. Хангай говийг заагласан алдар цуут Борогчийн хөндийн уужим дахь борхон гэрийн эзэгтэй гуч эргэм насны өндөр бор бүсгүй намхан зуухан дээрх тос дааварласан ширмэн тогооноос хуруу зузаан өрөм хаман авч шар*

*модон тавагт байгаа алгын чинээ хоёр цагаан хурууд дээр ижилхэн хувааж тавив. [...] г.м.*

**б. Эхзохиогчийн уран сэтгэмж, ургуулан бодохуйг илэрхийлж, эхийн өгүүлэмжтэй холбогдох үүрэг бүхий эхлэл:** Үүнд холбогдуулж хоёроос гурван баримт татаж харъя.

Д.Намсрайн “Жамухын өчил” өгүүллэгийн (урансайхны эхийн) эхлэл нь:

*Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр өнөөдөр талын болжмор жиргэж, эх нутгийн ноён салхинаа гудайсан хялганын толгой гашуудалтайяа бөхөлзөнө. Тэр газрын цээжийг аниртан чагнаваас монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ. [...]*

Ц.Дамдинсүрэн гуайн “Багш шавь хоёр” өгүүллэгийн ургуулан бодохуйн эхлэл нь маш сонирхолтойгоор зохиомжлогдсон байдаг. Үүнд:

*Зуны цаг Улаанбаатарын гудамжаар явж байтал, гудамжинд нэг цэцэг ургасан байв. Хээрийн цэцгийн үр салхинд хийсэж ирээд хотод ургаж байгаа юм байна.*

*Хотын хүн их төлөв зун цаг Туулын хөөөөгөөр гэр барьж зусланд суух тул зарим гудамжаар хүн явах нь цөөн болно. Ийм завшаанаар энэ цэцэг ургаж чадсан боловч зарим хүний хөлд гишгээгдэж, хотоор тэнэж явдаг ямаанд идээгдэж, тоосонд дарагдаад хээрийн цэцэгтэй зэрэгцүүлбэл их л гутанги болжээ*

*Удахгүй хотын хүнийг нүүж ирэхэд, энэ цэцэг хөлд гишгээгдэх нь лавтай. Хөөрхий цэцэг зохих газраа олж ургаж чадсангүй. Хэрэв цэцэрлэг юм уу байшингийн хайсанд ургасан бол өөрөө саадгүй сайн ургахын дээр хотын чимэг болж хүний сэтгэлийг баясгах зүйл болохсон билээ.*

*Түүний дэргэд намхан цагаан байшингийн хайсны дотор түүний төрлийн нэгэн бүлэг сайхан цэцэг ургаж, хурц өнгөө хүний нүдэнд тусгаж байна. Энэ цэцгийг хүн усалж арчилж байсан нь илэрхий. Үүнээс үзэхэд, аливаа юмыг бодлоготойгоор удирдах, ажиллах гэдэг их хэрэгтэй юм байна. Энэ бол зөвхөн цэцэгт ч биш, хүнд ч холбогдоно. Жишээ болгож таних нэг хүүхний явдлаас хэлье.*

Хөдөө газар малын ажилтай эмгэн өвгөн хоёр байжээ. Нэг хүүхэнтэй юмсанжээ. Түүний нэрийг Цэцэгмаа гэдэг. [...] гэж өгүүллэгийн өгүүлэгдэхүүн, дүрийн зөрчил, дотоод, гадаад талтай холбон нөхцөлдүүлдэг.

**в. Зохиолын (эхийн) өгүүлэгдэхүүн хийгээд зохиол дахь дүрүүдийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бүрдүүлэх зорилго, үүрэг бүхий бэлгэдэлзүйн шинжтэй эхлэл** цөөнгүй байдаг байна. Тухайлбал:

Ц.Дамдинсүрэн гуайн “Чемодантай юм” өгүүллэлт зохиолын өгүүлэгдэхүүн хийгээд дүрүүдийн зөрчлийг гаргаж, тодосгоход нэг нарийн холбоос болгож, дараах оруулбар байдалтай “эхлэл”-ийг хэрэглэсэн байдаг нь сонин юм. Энэхүү уран сэтгэмж, уран шийдэл нь:



[...] *Хоёр бүсгүйн өмнө зүлгэн дээр тарьсан алаг цэцэгс зөөлөн салхинд найгаж, Цээмаа, Бумаа хоёрт баяр хүргэх мэт дохилзож байна. Жаргаж байгаа нар далд орохынхоо өмнө амжиж хоёр бүсгүйг сайн ажиглаж авъя гэсэн юм шиг баруун байшингийн хажуугаар шуналтайгаар шагайна...*

*Сайхан цэцэрлэгийн дотор муухай хогтой өндөр төмөр сав “Юуг, яаж гутаах вэ” гэсэн юм шиг ёрдойж байна. Түүний хар сүүдэр нар доошлох тутам улам урт болсоор Цээмааг дамжаад Бумаагийн нарийхан шилбэн дээр тусаад, хугарч өрөөсөн хөлийг нь бугуйлдаад авсан юм шиг харагдана. [...]*

Б.Догмидын “Нутаг” өгүүллэгт эхзохиогчийн уран сэтгэмж, бэлгэдлийг илэрхийлсэн маягтай өвөрмөц **эхлэл** байдаг. Энэ нь мөн л зохиолын “**үйл явдал**” хийгээд өгүүлэгдэхүүний өрнөлд чухал үүрэгтэйгээр орсон дэвсгэр өгүүлэмж юм. Үүнд:

*Балдан өвгөн Талын хайрханы оройд гарч, лус савдгийг аргадан, сан тавьж, өл овоонд нь мөргөн, малгайн утаа сэргээгээд буцаж явлаа. Цагаан өвс аниргүйхэн ганхах их талд эл хульхан, бялзуухай ч үл жиргэх бөгөөтөл манан будангийн дуу л ийм байдаг болов уу гэмээр нэгэн бүдэгхэн цагаан аялгуу чихний үзүүрт сонсогдохтой үгүйтэй, холдон ойртон эгшиглэнэ. [...]* гэж эхэлсэн байдаг.

Жич тэмдэглэх нь, “Зохиолын явдлын системд шууд хамааралтай биш боловч уг хэрэг явдлын утга санааг нэмэн дэлгэрүүлэхэд тодотгол хийсэн шинжтэй тусгай хэсгийг оруулбар гэдэг” (3:20) бөгөөд дээр дурдсан Ц.Дамдинсүрэнгийн “**Чемодантай юм**”, Б.Догмидын “**Нутаг**” өгүүллэгийн **эхлэлүүд** нь урансайхны эхийн зохиомж дахь урансайхны оруулбар (insertion) шинжтэй юм гэж үзэж болмоор байна.

**г. Эхзохиогчийн бодрол бясалгал, зохиомжийн өмнөтгөл** буюу **тусгай тэмдэглэл маягтай эргэцүүлэмж эхлэл** хэсэг урансайхны найруулгын эхэд түгээмэл байдаг нь ажиглагдаж байна. Үүнд: Д.Маамын “**Хоёр хар буурын туурь**” хүүрнэлд: “**Тэмээ бол миний эхлэл, төгсгөл хоёрыг эзэгнэн заяагч эх сайхан оронтой минь намайг холбосон мянган шижим, түмэн зангилааны нэг нь ажээ гэдгийг магадгүй тэнд эхлэн ухаарсан байж мэдэх билээ**” [...] гэсэн сонирхолтой **эхлэл** байдаг. Тэгвэл Д.Нацагдоржийн “**Соёлыг гайхав**” өгүүллэгийн (урансайхны эхийн) **эхлэл нь**:

*Хаврын хурц наранд өвлийн хунгарласан цас хайлж, газрын хөрсийг чийгтүүлэн, өсөх төлжих ногоонд шимийг өгөх нь сайшаалтай боловч, тэрэгч Лувсангийн зуны халуунд хөлсөө урсгаж, өвлийн хүйтэнд хуруугаа хөлдөөж олсон муу гутлыг шавхайдан дүүргэх нь хайрлалтай [...]* гэсэн бодрол байдаг.

**д.** Урансайхны эхүүдийг ажиглахад, нэг талаас, зохиолын өгүүлэгдэхүүний чиглэлийг өөрчлөх эргэлт маягтай, нөгөө талаар, **хэлбэржсэн агуулгыг** илэрхийлэх ямар нэг дэвсгэр өгүүлэмж (эхлэл ч гэмээр) байдалтай тийм бүрдэл хэсэг байдаг байна. Уранзохиол задлалын онолд “Тухайн зохиолд агуулагдан багтсан бодит үзэгдлүүд,

түүнд шингэсэн зохиолчийн болоод нийгмийн үзэл бодол, санаа сэтгэл нь **хэлбэржсэн агуулгаар** дамжин илэрдэг аж. Жишээ нь Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” туужид гол баатар Долингорын гэрийн доторх байдлыг:

**“Хойморт бяцхан улаан авдартай, түүн дээр гүнгэрваатай бурхан тахьжээ. Өмнө нь цайны зориг авах цөгц ба хүж хатгах ховд байна. Зүүн талд нэг авдрын дээр аяга, цом, пял таваг зэрэг байна. Бусад зайд хуучин муусайн ширмэл ширдэг, уранхай тасархай хом зэргийг дэвсчээ.”** гэсэн энэ хэсэгт гэрийн доторх эд зүйлс түүний чанар сэлтийг тоочин гаргасан нь зохиолын санааг илэрхийлэх **хэлбэршлүүд** юм. Эдгээр хэлбэрийн дүрслэлүүдээр Долингорынх ядуу зүдүү амьдралтай айл юм байна гэсэн бодомж уншигчдад төрнө. Энд дан ганц агуулга биш, харин хэлбэрээр дамжин бий болсон **хэлбэржсэн агуулга** тодорч буй юм” (3:380) гэж үзжээ. Энэ бол зохиомжийн талаасаа дүрийн **агуулгыг** илэрхийлэх өвөрмөц нэгэн **хэлбэршилтийг эхлүүлж** буй хэсэг мэт санагдана. Тэгэхлээр **эхлэлийг** ямагт тухайн зохиол буюу тухайн эхийн эхэнд байрладаг гэж үзвэл ерөөсгөл байж болох билээ.

Эцэст нь дүгнэж тэмдэглэхэд, **эхлэл үг, эхлэл** хоёр нь нэг талаар, үүрэг, зорилгоороо ялгаатай бөгөөд **эхлэл нь** төрөл бүрийн найруулгын эхэд утга санааны холбогдлоороо эхийн өгүүлэмжийн зорилго, нөхцөл шалтгаан, орон, цаг, үйл явдлын болон дүрийн өрнөл, тайлбарласан тодотгол г.м. ямар нэгэн сэжмээр нэвчин холбогдсон бүтэц зохиомжийн бүрдэл хэсэг байдаг, нөгөө талаар, хэлийг хэрэглэх когнитив онол хийгээд дискурсын онолоор бол тухайн эхийг ойлгож хэрэглэх, хэлэх үйлдлийг төлөвлөх, хөтөлбөржүүлэх, бүтээх улмаар мэдээллийн ойлголт ба ухагдахуунуудын багцуудын сүлжээг үүсгэн бий болгоход чухал үүрэгтэй хэсэг гэж үзэж байна.

#### Ном зохиол

1. Гаадамба, Ш., Уранзохиолын онолын товч, Уб., 1958.
2. Галбаатар, Д., Эрс эргэлтийн босгон дээр, “Совин”, №10, Уб., 1996.
3. Галбаатар, Д., Уранзохиолын онолын ойлголт, нэртөмьёоны толь, нэмэн засварласан дөрөвдүгээр хэвлэл, Токио, 2002.
4. Пүрэв-Очир, Б., Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй, дэд дэвтэр, нэмсэн II хэвлэл, Уб., 2000.
5. Пүрэв-Очир, Б., Монгол хэлний эхзадлалын асуудлууд, Эхийн өгүүлбэрзүй, Уб., 2002.
6. Розенталь, Д.Э., Секреты стилистики, Айрис, М., 1999.
7. Сампилдэндэв, Х., Нийгмийн шилжилтийн үеийн уранзохиолын зарим асуудал, “Совин”, №16, 1997.
8. Солганик, Г.Я., Стилистика текста, учебное пособие для студентов, аспирантов, преподавателей – филологов гуманитарного профиля, Флинта-наука, М., 2002.
9. Сүхбаатар, Ц., Эхийн найруулгазүй, дэд дэвтэр, Уб., 2002.
10. Чулуундорж, Б., Когниц: сэтгэл судлал – хэлшинжлэл – мэдлэгийн онол, (лекцийн сэдвүүд), Уб., 2001.
11. Энхбаяр, С., Ирэх урсгал, “Зөн” №5, 1995.